

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

- | | |
|---------------|--|
| 1 дүгээр зүйл | Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заалт нэмэх |
| 2 дугаар зүйл | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим хэсэг, заалтыг өөрчлөн найруулах |
| 3 дугаар зүйл | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим хэсэгт өөрчлөлт оруулах |
| 4 дүгээр зүйл | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим хэсгийн үг хасах |
| 5 дугаар зүйл | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэсгийг хүчингүй болсонд тооцох |
| 6 дугаар зүйл | Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх хугацаа |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2027 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай 22 дугаар зүйлийн 22.1.11 дэх заалт нэмсүгэй:

“22.1.11.Монгол Улсын иргэний үргэлжилсэн таваас доошгүй жилийн хугацаанд өмчилсэн бөгөөд өөрийн үндсэн оршин суух хаягт бүртгэлтэй амьдран суух зориулалттай орон сууцаа борлуулж олсон орлого.”

2 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг:

“15.6.Татварын жилийн баталгаажсан тайлангаар 1 тэрбум хүртэлх төгрөгийн албан татвар ногдох орлоготой хувь хүний хүсэлтэд үндэслэн түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.”

2/23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг:

“23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт 9,504,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдох албан татварыг 100 хувиар хөнгөлнө.”

3 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсгийн “татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг” гэснийг “татварыг” гэж, 26 дугаар зүйлийн 26.1.1, 26.1.2, 26.1.3, 26.1.4, 26.1.5, 26.1.6, 26.1.7 дахь заалт, 26.5, 26.6 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 27.3, 27.4 дэх хэсгийн “15-ны өдрийн” гэснийг “сүүлийн өдрийн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.14 дэх хэсгийн “23.1, ” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн “, 23.1” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг